

Монгол-Япон эмнэлгийн мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн бие даах чадварыг үнэлэн хоорондын хамаарлыг судлах нь

Б.Оюунсүвд^{1,2}, В.Даваахүү³

¹АШУҮИС, Сувилахуйн сургууль, Насанд хүрэгчдийн сувиллахуйн тэнхим

²Монгол-Японы эмнэлэг

Цахим шуудан: oyunsuvd@mnums.edu.mn, Утас :88087319

Түлхүүр үг:

Хооллох
Хувцаслах
Өтгөн шингэнээ
барих
Хөдөлгөөн
Усанд орох

Товч утга:

Үндэслэл: Өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа (ADL) гэдэг нь бусдаас хараат бус амьдрахад зайлшгүй шаардлагатай өөрийгөө арчлах үйл ажиллагааг гүйцэтгэх чадварыг хэлнэ. Судлаач Costenoble A, Knoор V (2021) нарын судалгаагаар өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадвар алдагдах байдал нь физиологийн доройтлын хам шинж бөгөөд мэс засал хийлгэж буй эмчлүүлэгчдийн 60 хувьд өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадварын алдагдал илэрдэг гэжээ². Судалгааг Монгол Япон эмнэлгийн жишээн дээр хийсэн ба бие даах чадваруудын хоорондын хамаарлыг судалсан судалгаа харьцангуй цөөн байгаа тул энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** МЯЭ-ийн Мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн бие даах чадварыг үнэлэн, чадвар хоорондын хамаарлыг судлах. **Арга, аргачлал:** Энэхүү судалгааг агшингийн судалгааны загвараар тоон судалгааны аргаар АШУҮИС-ийн МЯЭ-ийн Мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлж хагалгаанд орсон 185 эмчлүүлэгчийг хамруулан бие даах чадварыг хагалгааны дараа үнэлсэн. Судалгаанд судлаач Катз (Katz et al. 1963) нарын боловсруулсан эмчлүүлэгчийн өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадварыг үнэлэх 6 асуулт бүхий стандарт асуумжаар хийж гүйцэтгэв. Судалгааны мэдээллийг SPSS-25.0 программд оруулж тархалтыг тодорхойлон, тархалт хэвийн бус байсан тул хувьсагчдын хоорондын хамаарлыг шалгахдаа спирменийн хамаарлын коэффициент (Spearman rank-order correlation) ашиглан хувьсагчдын хоорондын хамаарлын хүчийг тодорхойлов. **Үр дүн:** Судалгаанд хамрагдагсдын 50.8% (n=94) нь эрэгтэйчүүд, 49.2% (n=91)

нь эмэгтэйчүүд байв. Тэдгээрийн дундаж нас 47.09±14.56 жил, дундаж ор хоног нь 2.7±1.6 байв. Судалгаанд оролцогчдын бие даах чадварыг үнэлэхэд 11.9% (22) нь бусдаас бүрэн хараат, 21.1% (39) нь бие даах чадвар алдагдсан, 67% (124) нь бие даах чадвар хэвийн буюу сайн үнэлэгдэв. Бие даах чадвар хэвийн буюу сайн эмчлүүлэгчийн дундаж ор хоног 2.51±1.42, бие даах чадвар алдагдсан эмчлүүлэгчдийнх 2.79±1.73, бусдаас бүрэн хараат эмчлүүлэгчдийнх 3.6±2.03 байв. Эмчлүүлэгчийн бие даах чадварын үнэлгээ нь эмчлүүлэгчийн хэвтэх ор хоногтой ($r=0.159$, $p=0.03$) сул шууд хамааралтай байна. Хооллох чадвар нь хувцаслах чадвартай ($r=0.671$, $p=0.001$), усанд орох чадвартай ($r=0.568$, $p=0.001$), хөдөлгөөн хийх чадвартай ($r=0.571$, $p=0.001$), бие засах чадвартай ($r=0.588$, $p=0.001$), өтгөн шингэнээ барих чадвартай ($r=0.609$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байна. Хувцаслах чадвар нь усанд орох чадвартай ($r=0.766$, $p=0.001$), хөдөлгөөн хийх чадвартай ($r=0.723$, $p=0.001$), бие засах чадвартай ($r=0.788$, $p=0.001$), өтгөн шингэнээ барих чадвартай ($r=0.736$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байв. Усанд орох чадвар нь хөдөлгөөн хийх чадвартай ($r=0.789$, $p=0.001$), бие засах чадвартай ($r=0.715$, $p=0.001$), өтгөн шингэнээ барих чадвартай ($r=0.644$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байна. Хөдөлгөөн хийх чадвар нь бие засах чадвартай ($r=0.822$, $p=0.001$), өтгөн шингэнээ барих чадвартай ($r=0.770$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байна. Бие засах чадвар нь өтгөн шингэнээ барих чадвартай ($r=0.909$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байв. **Дүгнэлт:** Мэс заслын тасгаар эмчлүүлэгчдийн гуравны нэг нь мэс заслын дараа бие даах чадвар нь алдагдсан болон бусдаас бүрэн хараат байсан бөгөөд энэ нь ор хоног нэмэгдүүлэхэд сул шууд хамааралтай байна. Бие даах чадварыг тодорхойлдог чадварууд хоорондоо хүчтэй шууд хамааралтай байна.

Үндэслэл: Өдөр тутмын амьдралын суурь чадвар болох хооллох, усанд орох, хөдөлгөөн хийх гэх мэт өөрийгөө бие даан асрахад шаардлагатай үндсэн чадварын өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даах чадвар гэх нэр томъёог анх эрдэмтэн Катз (Katz) тодорхойлжээ¹. Судлаач Costenoble A (2021) нарын судалгаагаар өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадвар алдагдах байдал нь физиологийн доройтлын хам шинж бөгөөд мэс засал хийлгэж буй эмчлүүлэгчдийн 60 хувьд өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадварын алдагдал илэрдэг гэжээ².

Судлаач DeAngelo MM (2022) нар мэс заслын дараах асаргаа, сувилгааны хэрэгцээ нэмэгддэг ба урт ба богино хугацаанд тусламж шаардлагатай гэж үзжээ³. Судлаач De Roo (2020) судалгаандаа хүндрэлгүй мэс заслын дараах бие даах чадварын алдагдал 6-10% ($p < 0.001$), хөнгөн, дунд зэргийн хүндрэлтэй үед 18-28% ($p < 0.001$), хүндрэлтэй мэс заслын дараах бие даах чадварын алдагдал 2 дахин их байна гэсэн байна. (10-2, $p < 0.001$)⁴. Судлаач Ald-wikat RK (2023) нарын судалгаагаар Катзын индекс нь сэтгэл ханамжийн сэтгэлзүйн шинж чанартай бөгөөд өндөр настай хүмүүсийн үйл ажиллагааны байдлыг үнэлэх найдвартай, хүчинтэй хэрэгсэл гэж дүгнэсэн байна. Судлаач Hui-qin Zhi-xian (2013) нарын судалгаанд эмчлүүлэгчийн бие даах чадвар алдагдах тусам сувилахуйн тусламжийн хугацаа илүү урт байдаг гэж тодорхойлжээ. Сувилахуйн тусламжийг үзүүлэхдээ эмчлүүлэгчийн өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даах чадварыг үнэлэн гүйцэтгэх чадварт суурилан үзүүлэх нь сувилагчийн ажлын ачаалалд эерэг нөлөө үзүүлдэг гэж тодорхойлжээ⁵.

Үйлчлүүлэгчийн бие даах чадвар болох хооллох, хувцаслах, усанд орох, хөдөлгөөн, бие засах, өтгөн шингэнээ барих чадварыг КАТЗ-ийн үнэлгээгээр тодорхойлно⁶. Судлаач Л. Одгэрэл, З. Хишигсүрэн нарын өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд бие даах чадварын байдлыг судалсан судалгаанд 39% нь бусдаас бүрэн хараат, 61% нь бие даах чадвар буурсан байсан нь асран халамжилж байгаа хүндээ ачаалал үүсгэж байгааг нотолжээ. Судалгааг Монгол Япон эмнэлгийн жишээн дээр хийсэн ба бие даах чадваруудын хоорондын хамаарлыг судалсан судалгаа харьцангуй цөөн байгаа тул энэхүү судалгааг хийхээр болсон

Зорилго: МЯЭ-ийн Мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн бие даах чадварыг үнэлэн, чадвар хоорондын хамаарлыг судлах.

Арга, аргачлал: Судалгааг агшингийн сулалгааны загвараар тоон судалгааны аргаар АШУҮИС-ийн МЯЭ-ийн Мэс заслын тасагт 2023 оны 08-р сарын 15-ны өдрөөс 2024 оны 08 -р сарын 13-ны хооронд хэвтэн эмчлүүлж хагалгаанд орсон 185 эмчлүүлэгчийг хамруулан бие даах чадварыг хагалгааны дараа үнэлсэн. Судалгаанд судлаач Катз (Katz et al. 1963) нарын боловсруулсан эмчлүүлэгчийн өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадварыг үнэлэх 6 асуулт бүхий стандарт асуумжаар судалгааг хийсэн¹. Эмчлүүлэгчийн өдөр тутмын амьдралын үйл

ажиллагааг бие даан гүйцэтгэх чадварыг 10-12 оноотой бол “Бие даах чадвар хэвийн буюу сайн”, 6-9 оноотой бол “Бие даах чадвар алдагдсан”, 0-5 оноотой бол “Бусдаас бүрэн хараат” гэж тус тус дүгнэв. Асуумжийн найдвартай байдлыг тодорхойлоход cronbach α 0.87 байсан тул судалгааг хийсэн. Судалгаа хийх ёс зүйн зөвшөөрлийг АШУҮИС-ийн судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2022 оны 5-р сарын 20 ны 2022/3-05 тоот хурлын шийдвэрээр авсан.

Статистик боловсруулалт: Судалгааны мэдээллийг SPSS-25.0 программд оруулж өгөгдлийн алдааг хянаж дескриптив статистик шинжилгээ хийж, тархалт, хандлагыг тодорхойлсны дараа судалгааны зорилго, зорилтын дагуу таамаглал дэвшүүлэн тохирох статистик аргуудаар шалгаж p утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистикийн хувьд үнэн магадлалтай гэж үзэж, итгэх интервал 95 хувь байхаар тооцох бөгөөд түүврийн бус алдааг 10%-иар тооцсон. Тархалт хэвийн бус байсан тул хувьсагчдын хоорондын хамаарлыг шалгахдаа спирмений хамаарлын коэффициент (Spearman rank-order correlation) ашиглан хувьсагчдын хоорондын хамаарлын хүчийг r -утгаар илэрхийлсэн бөгөөд $r=0.10-0.29$ сул, $r=0.30-0.50$ дунд, $r>0.50$ хүчтэй хамааралтай гэж (Burns & Grove, 2005) нарын боловсруулсан балл оноогоор үр дүнг тайлбарлав⁷.

Үр дүн: Судалгаанд хамрагдагсдын 50.8% ($n=94$) нь эрэгтэйчүүд, 49.2% ($n=91$) нь эмэгтэйчүүд байв. Тэдгээрийн дундаж нас 47.9 ± 14.56 , дундаж ор хоног 2.7 ± 1.6 байв. Судалгаанд нийт 185 эмчлүүлэгч хамрагдсанаас цөсний хүүдий авах мэс засалд 53.3% (99), арьс, арьсан доорх эдийг зүсэх нээх ажилбарт 8.7% (16), хошног орчмын эд зүсэх тайрах ажилбарт 8.2% (15), бусад мэс ажилбарт 29.8% (55) тус тус орсон байв.

Судалгаанд оролцогчдын бие даах чадварыг үнэлэхэд 11.9% (22) нь бусдаас бүрэн хараат, 21.1% (39) нь бие даах чадвар алдагдсан, 67% (124) нь бие даах чадвар хэвийн буюу сайн байгаа тус тус тодорхойлов. Бие даах чадвар алдагдсан, бүрэн хараат эмчлүүлэгчдийг мэс заслын байдлаар авч үзэхэд ясны үрэвслийн мэс засал 3.24% (6), гар сарвууны мэс засал 2.7% (5), Элэг цөсний хавдрын мэс засал 2.7% (5) тус тус байв.

Судалгаанд хамрагдагсдын бие даах чадварууд хоорондыг хамаарлыг судлахад хооллох чадвар нь хувцаслах чадвартай ($r=0.671$, $p=0.001$), усанд орох чадвартай ($r=0.568$, $p=0.001$), хөдөлгөөн хийх чадвартай ($r=0.571$, $p=0.001$), бие засах чадвартай ($r=0.588$, $p=0.001$), өтгөн шингэнээ барих чадвартай ($r=0.609$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байв. Хувцаслах чадвар нь усанд орох чадвартай ($r=0.766$, $p=0.001$), хөдөлгөөн хийх чадвартай ($r=0.723$, $p=0.001$), бие засах чадвартай ($r=0.788$, $p=0.001$), өтгөн шингэнээ барих чадвартай ($r=0.736$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байна. Усанд орох чадвар нь хөдөлгөөн хийх чадвартай ($r=0.789$, $p=0.001$), бие засах чадвартай ($r=0.715$, $p=0.001$), өтгөн шингэнээ барих чадвартай ($r=0.644$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байна. Хөдөлгөөн хийх чадвар нь бие засах чадвартай

($r=0.822$, $p=0.001$), өтгөн шингэнээ барих чадвартай ($r=0.909$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байна (Хүснэгт 1).
($r=0.770$, $p=0.001$) хүчтэй шууд хамааралтай байна.
Бие засах чадвар нь өтгөн шингэнээ барих чадвартай

Хүснэгт 1. Мэс засалд орсон эмчлүүлэгчдийн бие даах чадваруудын хоорондын хамааралыг судасан дүн

Үзүүлэлтүүд	Хооллох чадвар	Хувцаслах чадвар	Усанд орох чадвар	Хөдөлгөөн хийх чадвар	Бие засах чадвар	Өтгөн, шингэнээ барих чадвар
Хооллох чадвар	1.000					
	.					
	185					
Хувцаслах чадвар	.671**	1.000				
	.000	.				
	185	185				
Усанд орох чадвар	.568**	.766**	1.000			
	.000	.000	.			
	185	185	185			
Хөдөлгөөн хийх чадвар	.571**	.723**	.789**	1.000		
	.000	.000	.000	.		
	185	185	185	185		
Бие засах чадвар	.588**	.788**	.715**	.822**	1.000	
	.000	.000	.000	.000	.	
	185	185	185	185	185	
Өтгөн, шингэнээ барих чадвар	.609**	.736**	.644**	.770**	.909**	1.000
	.000	.000	.000	.000	.000	.
	185	185	185	185	185	185

Түүнчлэн бие даах чадвар хэвийн буюу сайн чадвар алдагдсан эмчлүүлэгчийнх 2.79 ± 1.73 , бусдаас эмчлүүлэгчийн дундаж ор хоног 2.51 ± 1.42 , бие даах бүрэн хараат эмчлүүлэгчийн 3.6 ± 2.03 байв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Бие даах чадварын үнэлгээ ба дундаж ор хоногийн үзүүлэлтийг харицуулсан судалсан дүн

Үзүүлэлтүүд	бие даах чадвар хэвийн буюу сайн	бие даах чадвар алдагдсан	бусдаас бүрэн хараат
Дундаж ор хоног	2.51 ± 1.42	2.79 ± 1.73	3.6 ± 2.03

Эмчлүүлэгчийн бие даах чадварын үнэлгээ нь сул шууд хамааралтай байна (Хүснэгт 3).
эмчлүүлэгчийн хэвтэх ор хоногтой ($r=0.159$, $p=0.03$)

Хүснэгт 3. Эмчлүүлэгчийн бие даах чадварын үнэлгээ ба дундаж ор хоног хоорондын хамаарлыг судасан дүн

Үзүүлэлтүүд	корреляци	Дундаж ор хоног	Бие даах чадварын үнэлгээ
Дундаж ор хоног	Spearman's	1.000	
	P утга	.	
	N	185	
Бие даах чадварын үнэлгээ	Spearman's	.159**	1.000
	P утга	0.030	
	N	185	185

Хэлцэмж: Бид судалгаандаа мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэгчдийг хагалгааны дараа бие даах чадварыг 185 хүнд тодорхойлсон. Судлаач Aragao J.A (2023) нарын Бразил улсад хийгдсэн судалгаагаар бие даах чадварын оноо нь мэс заслын өвчинтэй холбоотой нөхцөл байдал, эмнэлэгт хэвтэхэд холбоотой

тогтоожээ⁸. Судлаач Josephine Neo (2017) судалгаагаар хорт хавдартай насанд хүрэгчдийн тал хувь нь бие даах чадвар алдагдсан, бүрэн хараат тусламж шаардлагатай байдаг гэдгийг тогтоожээ⁹. Бидний судалгаагаар судалгаанд оролцогчдын бие даах чадварыг үнэлэхэд 11.9% (22) нь бусдаас бүрэн хараат, 21.1% (39) нь

бие даах чадвар алдагдсан, 67% (124) нь бие даах чадвар хэвийн буюу сайн үнэлэгдсэн бөгөөд гуравны 1 нь бие даах чадвар алдагдсан, бүрэн хараат байсан. Судлаач Aragao J.A. (2023) нарын судалгааны үр дүнтэй дүйж байна. Харин судлаач Josephine Neo (2020) нарын судалгаагаар тал хувь нь бие даах чадвар алдагдсан, бүрэн хараат байсныг тогтоосон бөгөөд бидний судалгаагаар гуравны нэг нь бие даах чадвар алдагдсан, бүрэн хараат байгаа нь судлаач Josephine Neo (Жозефин Нео) нарын үр дүнгээс бага байна. Энэ нь судлаач Josephine Neo нарын судалгаа нь хорт хавдартай эмчлүүлэгчийн дунд хийсэнтэй холбоотой болов уу. Судлаач Gerrard P (2013) нарын 13113 эмчлүүлэгчийн дунд хийгдсэн судалгаагаар бие даах чадваруудыг эрэмбэлэхэд хооллох арай хялбар, усанд орох нь хамгийн хэцүү байдаг гэдгийг тодорхойлжээ⁹.

Дүгнэлт: Мэс заслын тасгаар эмчлүүлэгчдийн гуравны нэг нь мэс заслын дараа бие даах чадвар нь алдагдсан болон бусдаас бүрэн хараат байсан бөгөөд энэ нь ор хоног нэмэгдүүлэхэд сул шууд хамааралтай байна. Бие даах чадварыг тодорхойлдог чадварууд хоорондоо хүчтэй шууд хамааралтай байна.

Ном зүй:

1. Katz S, Ford AB, Moskowitz RW, Jackson BA, Jaffe MW. Studies of Illness in the Aged. *The Index of Adl: A Standardized Measure of Biological and Psychosocial Function*. JAMA. 1963;185:914-919.
2. Costenoble A, Knoop V, Vermeiren S, et al. A Comprehensive Overview of Activities of Daily Living in Existing Frailty Instruments: A Systematic Literature Search. *Gerontologist*. 2021;61(3):e12-e22.
3. DeAngelo MM, Holeman TA, Peacock JB, et al. Impact of frailty on risk of long-term functional decline following vascular surgery. *J Vasc Surg*. 2023;77(2):515-522.
4. De Roo AC, Li Y, Abrahamse PH, Regenbogen SE, Suwanabol PA. Long-term Functional Decline After High-Risk Elective Colorectal Surgery in Older Adults. *Dis Colon Rectum*. 2020;63(1):75-83.
5. Aldwikat RK, Manias E, Holmes AC, Tomlinson E, Nicholson P. Associations of postoperative delirium with activities of daily living in older people after major surgery: A prospective cohort study. *Journal of Clinical Nursing*. 2023.
6. яам Эм. Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний заавар. <https://moh.gov.mn/uploads/files/38b126c4446921db17bb63bb-56cec5057ded4347.pdf>; 2024 A/22.
7. Burns N, Susan K. Grove. *The Practice of Nursing research conduct critique and utilization 5th Edition Pennsylvania: Elsevier*. 2005.
8. Wallace M, Shelkey M. Katz index of independence in activities of daily living (ADL). *Urol Nurs*. 2007;27(1):93-4.
9. 蔡虹, 沈宁, 孙红, 郭红, 王雪莲. 综合性医院成年住院病人的直接护理时间与自理能力, 疾病严重程度相关性的研究. *中华护理杂志*. 2007;42(10):875-8.
10. Aragao JA, Neves OMG, Aragao ICS, et al. Occurrence of depression and assessment of functional capacity in patients with vascular diseases admitted to a Vascular Surgery Service. *J Vasc Bras*. 2023;22:e20230082.
11. Gerrard P. The hierarchy of the activities of daily living in the Katz index in residents of skilled nursing facilities. *J Geriatr Phys Ther*. 2013;36(2):87-91.

Investigating the Relationship Between Independent Functioning and Patients Admitted to the Surgical Department of the Mongolian-Japanese Hospital

Oyunsuvd B^{1,2}, Davaakhuu B²

¹School of Nursing, MNUMS

²Mongolia -Japan Hospital, MNUMS

E-mail: oyunsuvd@mnumns.edu.mn, Tel: +976-88087319

Background: Activities of Daily Living (ADL) refer to the essential self-care tasks necessary for independent living. A 2021 study conducted in France by researchers Axelle Kostenobel and Wierle Knoop found that the loss of independent functioning is a syndrome of physiological decline, with 60% of post-surgical patients experiencing a reduction in their independence. In Mongolia, there is limited research on the ability of post-surgical patients to perform daily activities independently. Therefore, this study was conducted to address this gap.

Aim: The objective of this study is to assess the level of independence among patients admitted to the Surgical Department of the Mongolian-Japanese Hospital and to analyze the interrelationships between different functional abilities.

Materials and Methods: This study was conducted as a cross-sectional quantitative study involving 185 patients who underwent surgery at the Surgical Department of the Mongolian-Japanese Hospital, affiliated with the Mongolian National University of Medical Sciences. The patients' independence levels were evaluated postoperatively using the standard six-question ADL assessment questionnaire developed by Katz et al. (1963). The collected data were analyzed using SPSS 25.0, with normality distributions assessed. Since the data did not follow a normal distribution, Spearman's rank-order correlation coefficient was used to determine the strength of associations between variables.

Results: Among the study participants, 50.8% (n=94) were male, and 49.2% (n=91) were female. The average age was 47.9±14.56 years, and the mean hospital stay was 2.7±1.6 days. The assessment of independence levels revealed that:

- 11.9% (n=22) were completely dependent,
- 21.1% (n=39) had impaired independence, and
- 67% (n=124) maintained normal or good independence.

The mean hospital stay for patients with normal or good independence was 2.51±1.42 days, while it was 2.79±1.73 days for those with impaired independence and 3.6±2.03 days for fully dependent patients. There was a weak positive correlation between independence level and length of hospital stay ($r=0.159$, $p=0.03$).

Strong direct correlations were observed between:

- Eating ability and dressing ability ($r=0.671$, $p=0.001$), bathing ability ($r=0.568$, $p=0.001$), mobility ($r=0.571$, $p=0.001$), toileting ability ($r=0.588$, $p=0.001$), and continence control ($r=0.609$, $p=0.001$).
- Dressing ability and bathing ability ($r=0.766$, $p=0.001$), mobility ($r=0.723$, $p=0.001$), toileting ability ($r=0.788$, $p=0.001$), and continence control ($r=0.736$, $p=0.001$).
- Bathing ability and mobility ($r=0.789$, $p=0.001$), toileting ability ($r=0.715$, $p=0.001$), and continence control ($r=0.644$, $p=0.001$).
- Mobility and toileting ability ($r=0.822$, $p=0.001$) and continence control ($r=0.770$, $p=0.001$).
- Toileting ability and continence control ($r=0.909$, $p=0.001$).

Conclusion: One-third of the patients admitted to the surgical department experienced a decline in independence or complete dependence postoperatively, which was weakly correlated with a longer hospital stay. The various functional abilities that determine independence were strongly interrelated.

Keywords: Eating, dressing, Continence control, Mobility, Bathing